



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

20 20 оны 04 сарын 30 өдөр

Улаанбаатар хот

Хурал болсон газар: Цахимаар дамжуулан хуралдав.

Хурал болсон он, сар, өдөр: 2020 оны 4 дүгээр сарын 30-ны Пүрэв гарагт

Хурал болсон цаг: 11 цаг 00 минут

Хурлын дарга: Мягмар овогтой Мөнхбаатар

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
3. ТУЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
4. ТУЗ-ийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай.

Хурлын ирц: 85.93 хувь

Хуралд биечлэн болон урьдчилан саналын хуудсаар оролцогчид:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Энгийн хувьцааны тоо ширхэг	Ирц
1	Т.Амгаланбаатар	1	0.00001%
2	Г.Сансар	31	0.00020%
3	Г.Дэлгэрмөрөн	81	0.00053%
4	А.Анар	2	0.00001%
5	Д.Байлхүү	295	0.00193%
6	Ж.Энхтунгалаг	1	0.00001%
7	BDSEC	2	0.00001%
8	Капитрон банк	210,631	1.38147%
9	Монгол улсын хөгжлийн банк	3,081,955	20.21366%
10	Голомт банк	1,023,699	6.71415%
11	Худалдаа хөгжлийн банк	2,069,00	13.56998%
12	"Ти Ди Би Капитал" ХХК	1,908,836	12.51951%
13	Монгол банк	210,621	2.76280%
14	УБ Хотын банк	2,070,912	13.58252%
15	Юнайтэд Секьюритис ХХК	1,976	0.01296%
16	Азиа дайверсифайд рийл истэйт фонд нэг ХХК	2,312,500	15.16703%

Хуралд оролцсон албан тушаалтан:

1. Б.Гантулга, “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал;
2. А.Анар, Үйл ажиллагааны газрын захирал;
3. Ц.Мөнх-Эрдэнэ, Мэдээлэл технологийн хэлтсийн захирал.
4. Х.Маралмаа, ТУЗ-ийн ажлын албаны хуульч

М.Мөнхбаатар: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэхэд бэлэн боллоо. Улсын онцгой комиссын шийдвэртэй уялдуулан “МИК Холдинг” ХК-ийн анхны цахим хурал эхлэхэд бэлэн боллоо. Тооллогын комиссын дарга ирцийг танилцуулна уу?

С.Амарсайхан: Сайн байцгаана уу? Та бүхэнд хурлын ирцийг танилцуулъя. 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хуралд нийт 13,101,082 хувьцаа эзэмшдэг 15 хувьцаа эзэмшигч урьдчилан саналын хуудсаар саналаа ирүүлэн оролцож байна. 81 хувьцаа эзэмшдэг 1 хувьцаа эзэмшигч оролцож байна. Нийт саналын эрхтэй хувьцааны 85.93 хувийн ирцтэй байна.

М.Мөнхбаатар: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулъя. 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 20/05 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2 хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, 2020 оны 3 дугаар сарын 05-ны өдөр нийт хувьцаат компаниудад хандан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, зайны технологийг ашиглан хуралдуулах тухай мэдэгдэл, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2, 9 дүгээр зүйлийн 9.7.11, 9.7.12 дахь заалтыг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт зарлаж Шангри-Ла зочид буудал, 1 давхар, Парис-Бээжин хурлын танхим (Монгол улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж-19)-д, эсвэл цахим болон зайны технологи ашиглан хуралдуулсугай. 2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд: 1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай; 1. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай; 3. ТУЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай; 4. ТУЗ-ийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай. 3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөр тогтоосугай. 4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д тус тус хүргүүлсүгэй. 5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 1-р баталж, 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр болон 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр тус тус хоёроос доошгүй өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай. 6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд: Комиссын дарга: Г.Саруул, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга; Гишүүн: Х.Маралмаа, ТУЗ-ийн ажлын албаны хуульч; А.Анар, “МИК ОССК” ХХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал; Ц.Мөнх-Эрдэнэ, “МИК ОССК” ХХК-ийн Мэдээлэл технологийн хэлтсийн захирал. 7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдэд тэдгээрт үйлчилж буй Үнэт цаасны

компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж, танилцах бололцоогоор хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай. 8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Мөнхбаатарыг томилсугай. 9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд: Комиссын дарга: С.Амарсайхан, “МИК ОССК” ХХК-ийн Эрсдэлийн удирдлагын газрын захирал; Гишүүн: Н.Энхмаа “МИК ОССК” ХХК-ийн Хянан нийцүүлэлтийн газрын захирал; Гишүүн: Б.Болортуяа, “МИК ОССК” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын захирал; Гишүүн: Б.Булган, “МИК ОССК” ХХК-ийн Санхүү, төлөвлөлт шинжилгээний хэлтсийн захирал. 10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг хурлын дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай. 11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт 3-р, санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр “Санал авах хуудас”-ны загварыг Хавсралт 4, 5-р тус тус баталсугай. 12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг үнэт цаасны компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т, хурлаар шийдвэрлэх асуудалд өгөх саналыг авах ажлыг хурлын мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 12:00 цаг хүртэл хүлээн авах, түүнтэй холбоотой бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Тооллогын комисс (С.Амарсайхан)-т тус тус үүрэг болгосугай. 13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай. 14. Онцгой нөхцөл байдалтай холбогдуулан гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэртэй уялдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, хуралдуулахыг Хурлын дарга (М.Мөнхбаатар), Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул) нарт тус тус үүрэг болгосугай. 15. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүйн хороо (Д.Аюуш)-нд үүрэг болгосугай. Тус тогтоолын дагуу хурал зарлагдан хуралдаж байна. Дараах асуудлуудыг өнөөдрийн хурлаар хэлэлцэхээр байна. 1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай; 2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай; 3. ТУЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай; 4. ТУЗ-ийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай. Эхний асуудлыг Гүйцэтгэх захирал Гантулга танилцуулна.

Б.Гантулга:

Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэнд 2019 оны үйл ажиллагааны тайлангаа танилцуулъя. Компанийн эрхэм зорилго нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган дотоод, гадаадын хөрөнгийн зах зээл дээр борлуулах замаар ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, Монгол Улсын хүн амыг орон сууцаар хангах, цаашид орчин үеийн хот байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн урт хугацаат санхүүжилтийн тогтолцоог бий болгож төлөвшүүлэхэд оршино. 2018 оноос эхлэн компани нь зээлжих зэрэглэлийн тогтоолгож ирсэн. 2019 оны байдлаар компанийн зээлжих зэрэглэл Монгол улсын зээлжих зэрэглэлтэй ижил тогтоогдсон байна. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд 19.13 хувь нь Монголбанк болон төрийн өмчит байгууллага, банк болон хувийн хэвшил 80.67 хувь, иргэд 0.6 хувь тус тус байна. Тайлант хугацаанд МИК ОССК ХХК, Протего Фөст ХХК, МИК Рийл Эстэйт ХХК гэсэн 3 охин компани байна. Үндсэн үйл ажиллагааг МИК ОССК ХХК-иар дамжуулан орон сууцны зээлийг худалдан авах үйл ажиллагаа эрхэлж байна. “МИК Рийл Эстэйт” ХХК нь үл хөдлөх хөрөнгө борлуулах худалдах гэсэн үндсэн чиглэлээр ажиллана. Протего Фөст ХХК нь одоогоор үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд цаашид шинэ төрлийн бүтээгдэхүүн буюу даатгалын чиглэлд төвлөрөн ажиллахаар төлөвлөж байна. Хувьцааны арилжааны мэдээллийг товч хүргэе. Нийт арилжаалагдсан тоо 65, Нийт арилжаалагдсан ширхэг 2,084, нийт ширхгээр арилжаалагдсан дүн 28 сая төгрөг, багцын арилжаагаар 61 тэрбум төгрөг тус тус арилжаалагдсан байна. Өнгөрсөн оны онцлох үйл явдлаас товч дурдъя. Олон улсын хөрөнгийн зах зээлд гурван жилийн хугацаатай, 9.75

хувийн хүүтэй 300 сая ам.долларын “Өэлүн” бондыг амжилттай арилжаалсан. Энэ нь Монгол улсаас олон улсын зах зээл дээр бонд гаргасан хувийн хэвшлээс 3 дах аж ахуйн нэгж, нийт бонд гаргасан 5 дах байгууллага болсон. Мөн банк, уул уурхайн салбараас бус бонд гаргасан анхдагч байгууллага болсон. 7, 9.12 саруудад 8 болон 5 хувийн хүүтэй 362 тэрбум төгрөгийн зээлийг худалдан авч үнэт цаасжуулсан. Буцаах нөхцөлтэй буюу олон улсын зах зээл дээр босгосон эх үүсвэрээр арилжааны нөхцөлтэй орон сууцны зээл, байгууллагуудын зээлүүдийг 7 банкнаас 700 тэрбум орчим төгрөгийн зээл худалдаж авсан. Мөн өнгөрсөн жил гадаад хамтын ажиллагааны чиглэлд Японы орон сууц санхүүжилтийн агентлагтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Тус санхүүжилтийн агентлаг нь анх удаа ногоон бонд гаргасан бөгөөд бид цаашид ногоон бондыг Монгол улсад нэвтрүүлэх цаашид гэр хорооллын дахин төлөвлөлт зэрэг бүтээн байгуулалтын чиглэл ногоон бондыг ашиглахаар төлөвлөж байна. Үндсэн бизнесийн үйл ажиллагаа маань Ипотекийн зээлийг худалдан авдаг. 2 төрлөөр худалдан авалт хийдэг. 1. Буцаахгүй нөхцөлтэй хэлцэл гэдэг нь Зээлийн хөрөнгөөс орж ирэх өгөөж болон учирч болох эрсдэлийг аль алиныг нь шилжүүлэн авах нөхцөлтэй хэлцэл, 2. Буцаах нөхцөлтэй хэлцэл гэдэг нь зээлийн хөрөнгөнд эрсдэл учирсан тохиолдолд эсхүл худалдагч талд буюу зээл олгосон банкинд тухайн зээлийн хөрөнгийг буцаан худалдах эсхүл өөр зээлийн хөрөнгөөр солих нөхцөлтэй хэлцлийг хийдэг. Өнгөрсөн жил 700 тэрбум төгрөгийн буцаах нөхцөлтэй, 326 тэрбум төгрөгийн буцаахгүй нөхцөлтэй гүйлгээг тус тус хийсэн. Үйл ажиллагаагаар дамжуулан бидний хүрч байгаа үнэ цэнэ бол арилжааны банкуудын хөрвөх чадварын удирдлагыг дэмжиж байна. Мөн ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргаж байгаа үндсэн шалтгаан нь зээлийг хөрөнгийн зах зээлд шилжүүлэх үндсэн үйл ажиллагааг гүйцэлдүүлж байна. Санхүүгийн үр дүнгийн хувьд нийт 31 хувиар өсөж 4.2 их наяд төгрөгт хүрсэн. Цэвэр хүүний орлого 80 тэрбум төгрөг, нэгж хувьцаанд ногдох ашиг нь 2.3 хувиар нэмэгдсэн. Санхүүгийн тайланд голлох нөлөө үзүүлсэн нь Өэлүн бондын эх үүсвэрийг ашиглахтай холбоотой. 2020 оны төлөвлөгөөний хувьд үндсэн үйл ажиллагааны хувь нийт 367 тэрбум төгрөгийн зээлийг банкуудаас худалдан авна. Үйл ажиллагааг сайжруулах чиглэлд компанийн түвшинд КРІ үнэлгээ хийлгэсэн. Мөн Олон улсын санхүүгийн корпорацын сайн засаглалын үнэлгээг хийлгэсэн. Үнэлгээний дагуу өгсөн зөвлөмжийг үйл ажиллагааны журмуудад тусган цаашид олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллахаар зорьж байна. Гадаад дотоо хамтын ажиллагааг өргөжүүлнэ. Мэдээлэл технологийн үйл ажиллагааг автоматжуулах үйл ажиллагааны хүрээнд хэд хэдэн үйл ажиллагаа төлөвлөн ажиллаж байна. Өэлүн бондын эх үүсвэрийг оновчтой болгохын тулд богино хугацааны мөнгөн урсгалыг боловсруулна. Хөрөнгийн зах зээлийг гүнзгийрүүлэхэд шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэхэд анхааран ажиллана. Хөрөнгийн биржтэй хамтран ажиллаж баталгаат бонд гаргах журмыг боловсруулна. Мөн банк бус санхүүгийн байгууллагаас өндөр өгөөжтэй багц худалдан авахаар судалж байна. Эдгээр ажлыг хийж гүйцэтгэхэд олон сорилтуудтай тулж байна. Ковид 19 холбоотой арга хэмжээ болох өргийн орлого буурахаас сэргийлэн хүү төлөлтийг 6 сараар хойшлуулж байгаа нь компанийн ашигт ажиллагаанд нөлөөлнө. Мако орчинд ажил эрхлэлт, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, банкны реформ хэрхэн өөрчлөгдөх зэрэг мөн нөлөөлнө. Микро орчин буюу цаашдаа анхаарал хандуулж байгаа гол асуудал бол орон сууцны хөтөлбөр цаашид яаж өөрчлөгдөхөөс хамаарч байна. Мөн орон сууц санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох тал дээр төр засгийн байгууллагуудтай хамтран ажиллахыг ирмэлцэнэ. Дараагийн хурлаар хэлэлцэх асуудлыг Мөнхбаатар танд шилжүүлнэ.

М.Мөнхбаатар:

Гантулга захиралд баярлалаа. Хурлын дэгийн дагуу 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай тогтоолыг уншиж танилцуулъя. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7.15 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн

дэргэдэх Санхүү, аудитын хорооны 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хурлын 6 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн тогтоох нь: 1. “Мэжик консалтинг аудит” ХХК-ийн гаргасан 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй. 2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй. 3. Энэ тогтоолын 2-т заасан санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэн байгууллагад хүргүүлэн хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн ажлын алба (Г.Саруул)-нд үүрэг болгосугай. 4. Энэ тогтоолын 2-т заасан тайлангуудыг ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэр гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай. 5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүй хороо (Д.Аюуш)-нд үүрэг болгосугай. Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудал танилцуулсны дараа хэлэлцэж байгаа асуудлын хүрээнд 15 минут асуулт хариулт явагдахыг дахин сануулъя. Хэлэлцэх асуудлын дагуу ногдол ашиг хуваарилах эсэх тухай тогтоолыг танилцуулъя. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6 дахь хэсэг, Компанийн дүрмийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн “Ногдол ашгийн бодлого”-ын 3 дугаар зүйлийн 3.3, 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь: 1. “МИК Холдинг” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай. 2. Энэ тогтоолын 1-т заасан шийдвэрийн үндэслэлийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай. 3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн ажлын алба (Г.Саруул)-д үүрэг болгосугай. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг танилцуулъя. Та бүхэн мэдэж байгаагчлан “МИК Холдинг” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь 2018 оны 4 дүгээр сарын 30-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 18/03 тоот тогтоолоор баталсан бүрэлдэхүүн ажиллаж байна. “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хурлыг 2019 онд нийт 13 удаа зарлан хуралдуулж, нийт 30 шийдвэр гарган ажилласан. “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ нь МИК ОССК-ийн ТУЗ-ийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьд тус компанийн ТУЗ-ийн хурлыг 2019 онд нийт 17 удаа зарлан хуралдуулж нийт 33 шийдвэрийг гаргасан. МИК ОССК-ийн ТУЗ нь Тусгай зориулалтын компанийн Хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьд компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, компанийн дүрмийг шинэчилж батлах, орон сууцны зээлийн хөтөлбөрийн хүрээнд нийт 326.2 тэрбум төгрөгийн ИЗББ арилжих зэрэг шийдвэрийг гаргасан. Мөн компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн дэргэд байнгын үйл ажиллагаа бүхийн 4 хороо үйл ажиллагаа явуулж ирлээ. Энэ жил өөрөө онцлогтой жил болж байна. 1 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн Улсын онцгой комиссын шийдвэр үндсэндээ үйл ажиллагаанд нөлөөлөх шинжтэй байна. Ковид 19 холбоотой өрх гэр, иргэдийн маань өдөр тутмын амьдралд нөлөөлөл харагдаж байна. Үүнтэй холбоотой тодорхой хүндрэлүүд компанийн үйл ажиллагаанд тулгарахаар байна. Монголбанк, Сангийн яам, Хот байгуулалтын яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтарч ажиллан байнгын мэдээлэл солилцон бодлогын арга хэмжээг дэмжин ажиллаж байна. Сүүлд хэрэглээний зээл болон орон сууцны зээлийн хүүгийн төлбөр болон үндсэн төлбөрийг хойшлуулсан. ИЗББ-г эзэмшдэг senior болон junior хөрөнгө оруулагчтай хамтарч шийдвэрийг гарган дээрх зээлүүдийг 6 сарын хугацаатай хойшлуулсан. Үүний хүрээнд junior бонд эзэмшигч, зарим senior бонд эзэмшигч нарт гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хэдийгээр орлого орж ирэхгүй байгаа зарим төлбөрийг анх 2013 оноос хойш бий болсон ИЗББ-ийн нөөц хөрөнгөөс төлөөд явж байна. Нягтлан бодох бүртгэлийн хууль болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хууль дээр энэ нь ашиг гэж харагддаг боловч хүндрэлийг даван туулахад зориулагдсан хөрөнгө байдаг. Энэ нь ИЗББ-ийн хугацаа дуусаад Тусгай зориулалтын компани нь хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсний дараа ашиг болдог хөрөнгө юм. Бидний хүлээгдэж байгаагаар энэ 6 сарын хугацаанд 120 орчим тэрбум төгрөгийг өнгөрсөн 7 жилийн хугацаанд бүрдүүлсэн хөрөнгөөр эрсдэлийг хаахаар байна.

Зөвхөн Монгол улс гэлтгүй дэлхий даяар үүсээд байгаа эдийг засгийн хямрал болох магадлал өндөр байна. Үүнтэй зэрэгцээд 2019 онд олон улсын санхүүгийн зах зээл дээр гаргасан бондын үнэлгээ унаж байна. Анх 9.75 хувийн өгөөжтэй гаргасан бол 9.25 хувийн өгөөжтэй болж буурсан. Одоо үүсээд байгаа нөхцөл байдлын талаар гадаадын хөрөнгө оруулагчдад зөв мэдээлэл хүргэх шаардлага үүсэж байна. Хамгийн сүүлийн асуудал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах асуудал байна. Өнгөрсөн жилийн төсвөөс нэмэгдээгүй. Хүргэгдсэн материалаас та бүхэн харж болно. Асуулт хариулт авах 15 минут эхэлж байна. Асуулт орж ирсэн байна.

Би Ди Сек ҮЦК: 2019 оны олон улсын зах зээлд гаргасан Өэлүн бондын эх үүсвэрээс ямар төрлийн зээлийн багц худалдан авч байна вэ? Орон сууцны зээл болон арилжааны зээл гэх мэт. Зээлийн багцын хүү ойролцоогоор хэд байна вэ?

М.Мөнхбаатар: Энэ бондын зорилго нь тодорхой байсан. Монгол арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийг худалдан авах зорилгоор гаргасан. Бондын өөрийн хүү маань 9.75 хувь, нэмэх нь swap хэлцлийн зардал зөвхөн 14 хувь болсон. Арилжааны банкуудаас 16 хувийн хүүтэй моргейжийн зээлийг худалдаж авсан. Та бүхэн дэлгэрэнгүй мэдээлэл авахаар бол компанид хандаж болно. Мөн жилийн тайланд дэлгэрэнгүй мэдээлэл оруулсан. Хурлын дэгийн дагуу асуулт хариултын 15 минут дууслаа. Хурал зохион байгуулах комиссоос саналын хуудас тараасан байна. Зарим хувьцаа эзэмшигч урьдчилан ирүүлсэн. Санал хураалт эхэлснийг мэдэгдье. Санал хураалт дууслаа. Тооллогын комиссын дарга Амарсайхан санал хураалтын дүнг танилцуулна.

С.Амарсайхан: Компанийн 2019 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай асуудалд нийт 13,101,163 хувьцаа эзэмшигч буюу 85.93 хувийн ирцтэй, 100 хувийн саналаар зөвшөөрсөн. Татгалзсан болон түтгэлзсэн санал өгөөгүй байна. 2 дугаар асуудал буюу ТУЗ-ийн 2020 оны зардлын төсөв батлах асуудалд нийт 13,101,163 хувьцаа эзэмшигч буюу 85.93 хувийн ирцтэй, 100 хувийн саналаар зөвшөөрсөн. Татгалзсан болон түтгэлзсэн санал өгөөгүй байна.

М.Мөнхбаатар: Баярлалаа. “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя. 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 20/02 Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хурлын 20/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон “Мэжик консалтинг аудит” ХХК-ийн гаргасан 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай. 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 20/03 дугаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь: 1. “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай. 2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо (М.Мөнхбаатар)-нд даалгасугай. Тогтоолууд батлагдлаа. “МИК Холдинг” ХК-ийн анхны цахим хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөж байна. Хуралд идэвхтэй оролцсон та бүхэнд баярлалаа.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:



Г.САРУУЛ
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

М.МӨНХБААТАР
Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга